



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 9 дүгээр Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/155/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	10
4.1 Залруулсан алдаа	10
4.2 Төлбөрийн акт	10
4.3 Албан шаардлага	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

᠘᠐᠔᠒.᠐3.᠒3 № 328

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 40,242.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй, ажил олгогчийн НДШ-ийн 594.7 мянган төгрөгийг цалингийн зардлаас, 18,000.0 мянган төгрөгийн материалыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас төлж батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрүүлэн зарцуулсан, 31,202.9 мянган төгрөгийн барааг хэрэгцээнээс илүү авч нөөцөлсөн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалт, Сангийн сайдын 190-р тушаал, Төсвийн тухай хуулийн 6.4.1 заалт, УСНББОУС-1,2,12,24 холбогдох заалтуудтай нийцэхгүй тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

023080498

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
- 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгсгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,180,111.50	143,175,342.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	73,180,111.50	143,175,342.50
351	Түүхий эд материал	220,000.00	984,398.00
35130	Эм боох материал	220,000.00	984,398.00
354	Хангамжийн материал	72,960,111.50	142,190,944.50
35410	Бичиг хэргийн материал	3,751,100.00	4,461,698.00
35420	Аж ахуйн материал	803,150.00	2,155,120.00
35440	Түлш, шатах тослох материал	500,000.00	-
35450	Барилгын засварын материал	225,345.00	29,343,585.00
35460	Хүнсний материал	2,059,610.00	3,298,015.00
35470	Бусад хангамжийн материал	65,620,906.50	102,952,526.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,035,933,622.31	2,019,779,466.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,035,933,622.31	2,019,779,466.90
392	Биет хөрөнгө	2,034,746,122.30	2,018,841,966.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,970,158,000.00	1,970,158,000.00
39202	Хуримлагдсан элэгдэл	(10,945,322.24)	(43,781,288.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,729,008.21	69,418,808.21
39206	Хуримлагдсан элэгдэл	(910,964.72)	(7,299,784.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,965,445.25	36,968,445.25
39208	Хуримлагдсан элэгдэл	(1,250,044.20)	(6,622,213.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	-
39215	Хуримлагдсан элэгдэл	-	-
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	1,187,500.01	937,500.05
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримлагдсан элэгдэл	(62,499.99)	(312,499.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,109,113,733.81	2,162,954,809.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,380,850.00	1,255,078.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,380,850.00	1,255,078.92
413	Өглөг	2,380,850.00	1,255,078.92
41310	Ажилгчидтай холбогдсон өглөг	-	1,255,078.92
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,380,850.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,106,732,883.81	2,161,699,730.48
51	Засгийн газрын хувь оролцоо	2,106,732,883.81	2,161,699,730.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч - төрийн	-	-
512	Хуримлагдсан үр дүн	2,106,732,883.81	2,161,699,730.48
51210	Өмнөх үеийн үр дүн	2,106,732,883.81	2,106,732,883.81
51220	Тайланг үеийн үр дүн	-	54,966,846.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,109,113,733.81	2,162,954,809.40

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,397,907,114.96	570,537,898.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,039,065,114.96	7,244,498.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,039,065,114.96	7,244,498.00
120001	Хувьцааны ногдол ашиг	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,039,065,114.96	7,244,498.00
1200045	Үндэстэй төлбөргүй хүтээн авсан орлого	2,039,065,114.96	7,244,498.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	358,842,000.00	563,293,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	358,842,000.00	497,125,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	337,490,200.00	497,125,700.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	21,351,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,314,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчийн хуваарилсан хөрөнгө	-	1,270,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	64,853,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	64,853,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	291,174,231.15	515,571,051.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	291,174,231.15	515,571,051.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	202,982,204.46	478,160,165.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,729,839.00	309,804,899.50
210101	Үндсэн цалин	101,782,992.00	278,185,659.71
210102	Нэмэгдэл	1,538,210.00	2,348,885.79
210104	Урамшуулал	10,408,637.00	29,270,354.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,192,651.31	41,391,631.08
210201	Тэтгэврийн даатгал	9,673,690.64	29,074,424.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,115,563.99	3,079,244.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	917,968.84	2,463,686.71
210204	Ажилгүйдлийн даатгал	205,129.90	615,849.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,280,297.94	6,158,426.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,731,603.00	52,071,934.70
210301	Гэрэл, цахилгаан	1,341,356.00	3,141,459.70
210302	Түлш, халаалт	19,647,397.00	45,637,794.00
210303	Цэвэр, бохир ус	2,742,850.00	3,292,681.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,787,600.00	9,918,090.00
210401	Бичиг хэрэг	1,237,400.00	1,387,400.00
210402	Гээвэр, шатахуун	1,350,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	113,000.00	1,063,040.00
210404	Нөм, хөвдөл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	553,400.00	384,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,011,150.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	533,800.00	72,500.00
210408	Бараа материал акаласны зардал	-	-
2105	Нормативт зардал	28,236,200.00	16,328,385.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,500.00	418,500.00
210502	Хөвдөл, хүүс	28,153,700.00	15,811,905.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	97,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,655,480.00	1,745,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	600,000.00
210604	Урсгал засвар	5,655,480.00	1,145,880.00
2107	Томилголт, зочны зардал	-	128,000.00
210702	Дотоод албан томилголт	-	128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	187,940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	-	187,940.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,648,831.15	46,583,405.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	207,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,000.00	1,529,450.00
210903	Үндсэн хөрөнгийн олгөдөл, хорогдол	13,168,831.15	44,846,955.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,192,026.69	37,410,885.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	299,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, цагнал урамшуулал	500,000.00	299,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,047.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,047.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87,690,979.69	621,535.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,690,979.69	401,235.30
213405	Нэмэлт санхүүжилт /төвлөрүүлэх шилжүүлэг/	-	220,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	36,489,550.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	36,489,550.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,106,732,883.81	54,966,846.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,106,732,883.81	54,966,846.67

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын өрүүлсэн капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,106,732,883.81	2,106,732,883.81
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,106,732,883.81	2,106,732,883.81
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	2,106,732,883.81	2,106,732,883.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,106,732,883.81	2,106,732,883.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	54,966,846.67	54,966,846.67
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,161,699,730.48	2,161,699,730.48

Хэрлэн сумын 9 дүтээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгсгөл/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	358,842,000.00	563,293,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	358,842,000.00	563,293,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	358,842,000.00	497,125,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	337,490,200.00	497,125,700.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	21,351,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,314,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,279,000.00
131105	Төсвийн байр ууламгийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	64,853,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	64,853,700.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	320,464,620.00	540,498,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	320,464,620.00	540,498,600.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232,272,593.31	503,087,714.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,729,838.00	309,750,353.15
210101	Үндсэн цалин	101,782,991.00	278,131,113.36
210102	Нэмэгдэл	1,538,210.00	2,348,885.79
210104	Урамшуулал	10,408,637.00	29,270,354.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,192,652.31	40,191,098.51
210201	Тэтгэмжийн даатгал	9,673,691.61	27,873,891.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,115,563.99	3,079,244.66
210203	ҮОМШО-ний даатгал	917,968.84	2,463,686.71
210204	Ажил үйлдлийн даатгал	205,129.93	615,849.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,280,297.94	6,158,426.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,350,753.00	54,452,784.70
210301	Гэрэл, цахилгаан	1,341,356.00	3,141,459.70
210302	Тусгай халаалт	19,647,397.00	45,637,794.00
210303	Цэвэр, бохир ус	362,000.00	5,673,531.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,526,185.00	21,326,768.00
210401	Бичиг хэрэг	3,273,000.00	1,639,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,850,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	113,000.00	1,063,040.00
210404	Ном, хэвлэл	80,000.00	72,498.00
210405	Хөгжлийн байгуулал, мөртөн зэрэгчдийн устгал, эрхтгал	210,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,000,185.00	17,571,630.00
2105	Нормативт зардал	48,003,705.00	29,746,990.00
210501	Эм, бэлдмэл, эмгэлгийн хэрэгсэл	78,000.00	948,900.00
210502	Хоол, хүнс	30,213,310.00	17,050,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,712,395.00	11,747,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,872,960.00	14,529,580.00
210601	Бараа, техник, мэргэжэл	6,872,960.00	4,529,900.00
210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	-	9,999,680.00
2107	Томилголт, зочны зардал	-	128,000.00
210702	Дотоод албан томилолт	-	128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	18,415,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад шийтгэл ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	18,415,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,596,500.00	14,546,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	207,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,596,500.00	14,339,440.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,192,026.69	37,410,885.64
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	299,800.00
213209	Нэг удаагийн гэгтэмж, шагнал урамшуулал	500,000.00	299,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,047.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,047.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87,690,979.69	621,535.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,690,979.69	401,235.30
213405	Нэмэлт санхүүжилт /төвлөрүүлэх шилжүүлэг/		220,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	36,489,550.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	36,489,550.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	38,377,380.00	22,794,800.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	38,377,380.00	22,794,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,377,380.00	22,794,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	38,377,380.00	22,794,800.00
222001	Тоног төхөөрөмж	21,007,380.00	-
223001	Бусад хөрөнгө	17,370,000.00	22,794,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(38,377,380.00)	(22,794,800.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	561,979,400.00	525,088,614.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,979,400.00	525,088,614.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	561,679,400.00	524,788,814.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	329,005,300.00	309,750,353.15
210101	Үндсэн цалин	203,585,800.00	278,131,113.36
210102	Нэмэгдэл	92,223,400.00	2,348,885.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	33,196,100.00	29,270,354.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,645,700.00	40,191,098.51
210201	Тэтгэврийн даатгал	34,615,800.00	27,873,891.73
210202	Тэтгэмжийн даатгал	3,757,500.00	3,079,244.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,006,000.00	2,463,686.71
210204	Ажилгүйдлийн даатгал	751,500.00	615,849.02
210205	Эрүүл мэндийн даатгал	7,514,900.00	6,158,426.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,853,700.00	54,452,784.70
210301	Гэрэл, цахилгаан	3,200,000.00	3,141,459.70
210302	Түлц, халаалт	45,653,700.00	45,637,794.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	5,673,531.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,719,400.00	21,651,768.00
210401	Бичиг хэрэг	1,639,600.00	1,639,600.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,113,100.00	1,063,040.00
210404	Ном, хэвлэл	85,400.00	72,498.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	480,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,901,300.00	17,896,630.00
2105	Нормативт зардал	37,265,700.00	29,568,990.00
210501	Эм, бэлдмэл, эмгэглэлийн хэрэгсэл	778,500.00	770,900.00
210502	Хоол, хүнс	24,734,000.00	17,050,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,753,200.00	11,747,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,500,000.00	36,499,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,500,000.00	26,499,700.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,999,680.00
2107	Томилголт, зочны зардал	142,600.00	128,000.00
210702	Дотоод албан томилголт	142,600.00	128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	18,000,000.00	18,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	18,000,000.00	18,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,547,000.00	14,546,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	207,000.00	207,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,340,000.00	14,339,440.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	299,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	299,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	299,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	561,979,400.00	525,088,614.36
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497,125,700.00	460,636,149.66
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	497,125,700.00	460,636,149.66
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,853,700.00	64,452,464.70
132001	Орон нутгийн төсвөөс	64,853,700.00	64,452,464.70

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ПЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,314,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,314,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,093,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	500,000.00
2105	Нормативт зардал	-	178,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	178,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	415,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	415,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		220,300.00
213405	Орон нутгийн төсвийн эрхлэхийн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		220,300.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,314,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,314,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,279,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор П.Мөнгөнтуул, аудиторын туслах Ж.Батсайхан нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 291,174.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,911.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,329.4 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,841.1 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	73,180.10	143,175.30	69,995.20
Үндсэн хөрөнгө	2,035,933.60	2,019,779.50	(16,154.10)
Нийт хөрөнгө	2,109,113.70	2,162,954.80	53,841.10
Өр төлбөр	2,380.80	1,255.10	(1,125.70)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,106,732.90	2,161,699.70	54,966.80
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	2,106,732.90	2,106,732.90	-
Тайлант үеийн үр дүн		54,966.80	54,966.80
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,109,113.70	2,162,954.80	53,841.10

Бараа материалын дансны үлдэгдэл нь 143,175.3 мянган төгрөг болж 69,995.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 102,578.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 26,685.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, барилгын засварын материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,019,779.5 мянган төгрөг болж 21,641.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 44,436.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 53,841.1 мянган төгрөг болж, 53,841.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлсөн байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,827,443.2 мянган төгрөгөөр буюу 76.2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй авсан орлого 2,003,480.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 223,986.2 мянган төгрөгөөр буюу 76.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл цалингийн зардал 196,075.4 мянган төгрөг, НДШ-ийн зардал 27,199.0 мянган төгрөг, түлш халаалтын зардал 25,990.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 8 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 358,842.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 203,137.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн нийт зарлагыг 561,979.4 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: түлш халаалтын зардлыг 24,001.9 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 185,276.9 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 31,679.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 561,979.4 мянган төгрөгөөр баталсанаас 497,125.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 64,853.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 497,125.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 64,853.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 525,088.6 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 36,489.6 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 401.2 төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 525,088.6 мянган төгрөг буюу 93.4 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 19,255.0 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 7,683.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 1,279.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35.0 мянга, нийт 1,314.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 1058.7 мянган төгрөгийг зарцуулж, 220.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны сайтад оруулбал зохих 144 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй учир өгөгдсөн зөвлөмж байхгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 124,329.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,898.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 97,208.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 21,222.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж дахин давтахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалд 5,898.0 мянган төгрөгийн хивс, дрож, бутлагч бүртгэснийг залруулж үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

4.3. Аудитаар 97,208.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өглөө. Үүнд:

4.3.1 Жилийн эцэст 40,242.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3.2 Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлын хэмнэлтээс 5,344.8 мянган төгрөгийн албан конторын тавилга, 1,823.5 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч нийт 7,168.3 мянган төгрөгийн зардал гаргасан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3.3 Ажил олгогчоос төлөх 594,8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн зардлаас төлсөн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас 18000.0 мянган төгрөгийн материал худалдан авсан. Нийт 18594.8 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангилал зөрүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3.4 Хэрэгцээнээс илүүдэлтэй 31202.9 мянган төгрөгийн бичгийн цаас, даавуу, банз зэрэг материал бэлтгэсэн

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт: _____

4.4.1. Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 21,222.7 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2.1.1 дүгээр заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хэрлэн сумын 9 дүгээр Цэцэрлэг	6	124329,5	1	5898,0			4	97208,8	1	21222,7
Дүн		6	124329,5	1	5898,0			4	97208,8	1	21222,7



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 223/23910610
ХТЭА 2022/155/НА-СТА 7ШБ

Чингис хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст 40,242.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2 "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгө, материалын тооллогыг хуульд заасан хугацаанд үнэн зөв хийж, үр дүнг тооцож, үлдэгдлийг баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунгэрэл, нягтлан бодогч Т.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 224/23910610
ХЭА-2022/155/НА-ӨА-ТШС

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст хэрэгцээнээс илүүдэлтэй 31,202.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл. 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4 "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунгэрэл, нягтлан бодогч Т.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Б.МАНАЛСҮРЭН

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 225/23910610
ХТЭ - 2022/155/НА СТА ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажил олгогчоос төлөх 594.8 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас төлсөн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас 18,000.0 мянган төгрөгийн материал худалдан авч батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулдаггүй зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунгэрэл, нягтлан бодогч Т.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 222/23910610

ХТТ - 2022/155/НА - ЕТТ - ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 5,344.8 мянган төгрөгийн албан конторын тавилга, 1,823.5 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авсан.

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д “автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8 “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Хэрлэн сумын есдүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунгэрэл, нягтлан бодогч Т.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

2317144297
СНОА0046 9074082